

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ОТОНГИС

МЭРГЭЖЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ  
ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2021 оны 02 дүгээр  
сарын 04-ны өдөр

Дугаар .....  
21-004

9006109  
9019120386

Улаанбаатар хот

## ЗОРИЛГО

“Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө”-нд хийж буй гүйцэтгэлийн аудитын хүрээнд улсын хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ үр нөлөөтэй эсэх, агаарын чанар болон агаар, орчны бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

### 1. ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 5, 2020 оны 4 дүгээр тогтоол, Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 4/233 дугаар албан бичиг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу агаар, орчны бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаарх судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийсэн туршлагатай, хүний их эмч, нийгмийн эрүүл мэндийн судлаач болон хими, физикийн ухааны мэргэжлээр мэргэшсэн хүний нөөц бүхий мэргэжлийн байгууллага, баг, иргэнийг аудитад шинжээчээр ажиллуулах шаардлагатай байна.

### 2. ЗОРИЛТ

Шинжээч нь Монгол Улсын агаар, орчны бохирдлыг бууруулах бодлого, хөтөлбөрийн хүрээнд 2017-2020 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ үр нөлөө үзүүлж, 2016 оны суурь түвшнээс агаарын чанар, агаар, орчны бохирдоос шалтгаалсан өвчлөл, нас баралт буурсан эсэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт Эрүүл мэндийн яамны хариуцан хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн, сайжруулсан түлш ашигласнаар хүн амын эрүүл мэндэд зэрэг, сөрөг ямар нөлөө үзүүлж байгаа, цаашид олон улсын шилдэг туршлагыг ашиглан түргэн хугацаанд үр дүнд хүрэх, агаар орчны бохирдлыг бууруулах боломжийг холбогдох баримт материалд үндэслэн судалгаа хийж мэргэжлийн түвшинд шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна.

### 3. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖИЛБАРУУД

Шинжээч нь ажлын даалгаварт туссан зорилтын хүрээнд дараах ажилбаруудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Монгол Улсын агаар, орчны бохирдлыг бууруулах бодлого хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ үр нөлөө үзүүлж, 2016 оны суурь түвшнээс агаар, орчны бохирдлын чанар, агаар, орчны бохирдлоос шалтгаалсан өвчлөл, нас барагт буурсан эсэх;
- 3.2. Сайжруулсан түлш ашигласнаар хүн амын эрүүл мэндэд эерэг, сөрөг ямар нөлөө үзүүлж байгааг харьцуулсан шинжилгээ, дүгнэлт хийх;
- 3.3. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт Эрүүл мэндийн яамны хариуцан хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх;
- 3.4. Цаашид агаар, орчны бохирдлыг бууруулах олон улсын шилдэг туршлагыг ашиглан түргэн хугацаанд үр дүнд хүрэх боломжийн талаар судалгаа хийж, оновчтой, хэрэгжүүлж болохуйц санал боловсруулах;
- 3.5. Бусад хийж хэрэгжүүлсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажил, баримт нотолгоонд тулгуурлан дун шинжилгээ, тайлан боловсруулах;
- 3.6. Тус аудитын үйл ажиллагаатай холбоотой Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хийсэн судалгааны мэдээллийг холбогдох агуулгаар ангилан аудитын тайланг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

#### **4. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Шинжээч нь Аудитад “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, “Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр” болон бусад төсөл, хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, тэдгээрийн ажлын алба, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрыг хамруулна.

#### **5. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН**

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанаарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын зорилт үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж дүгнэлт гаргаж, үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланда дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дун шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

#### **6. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Гуравдугаар газрын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаварт тусгагдсан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Гуравдугаар газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

## 7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Шинжээч нь аудитын тайлагналын үе шатны хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

**Эхлэх хугацаа:** 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр

**Дуусах хугацаа:** 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

Шинжээч нь ажлын явцыг дараах хугацааны дагуу аудитын багт тайлагнана.

- Явцын ажлын тайланг 02 дугаар сарын 26-ны дотор
- Эцсийн ажлын тайлан, дүгнэлтийг 03 дугаар сарын 12-нд хүлээлгэн өгнө.

## 8. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжлийн байгууллага, баг, иргэн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Агаар, орчны бохирдлын чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан туршлагатай байх;
- Судалгаа, эрдэм шинжилгээний үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг байх;
- Өөрийн судалгаа, шинжилгээний лабораторитой байх;
- Агаар, орчны бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн талаар судалгаа хийж, дүн шинжилгээ боловсруулах мэргэжлийн хүний нөөцтэй байх;
- Нийгмийн эрүүл мэнд судлаач, эмч болон бусад нарийн мэргэжлийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай байх.
- Төрийн болон албаны, байгууллагын нууц хадгалах чадамжтай байх.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт тусгасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоолол, санал, тайлбар, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг цаг хугацаанд нь үнэн зөв чанартай хийх үндсэн шаардлагыг хангасан байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

## 9. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хэлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

**Хянасан:**

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЭНХБОЛД

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

З.АРИУНЗАЯА

**Боловсруулсан:**  
АУДИТОР

Б.ДОЛГОРСҮРЭН

М.БАЯРТОГТОХ